



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
“ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН
СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИ

45000 Дархан, Дархан-Уул аймаг
Утас: 7037-3022, Факс: 7037-3021
И-мэйл: darhanpp@mongol.net

2023.12.20 № 1/402

танай _____ -ны № _____ -т

Г БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ Г
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН
БУЙ ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН
УДИРДЛАГЫН ГАЗАРТ

Дарханы дулааны цахилгаан станц ТӨХК-ийн
2023 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлэв.

2024 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөг баталгаажуулж өгнө үү.

Хавсралт. 3 хувь нийт..... хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ЖАРГАЛСАЙХАН



ГАРЧИГ

Бүлэг 1. Төслийн товч танилцуулга.....	2
1.1. Төслийн нэр.....	2
1.2. Төсөл хэрэгжүүлэгч.....	2
1.3. Төслийн талбайн байршил.....	2
1.4. Төслийн товч тодорхойлолт.....	4
Бүлэг 2. Төслийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч тодорхойлолт.....	6
2.1. Төслийн байгаль орчны тодорхойлолт.....	6
2.1.1. Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл.....	6
2.1.2. Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөл.....	8
2.1.3. Агаарын чанарын төлөв байдал.....	9
2.1.4. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн судалгаа.....	10
2.1.5. Төслийн талбайн ургамлын судалгаа.....	14
2.1.6. Гадаргын ус.....	17
2.1.7. Газрын доорх ус.....	18
2.2. Нийгэм-эдийн засгийн товч тодорхойлолт.....	22
Бүлэг 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ..	24
3.1.2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	25
3.1.3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	26
3.1.4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	27
3.1.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	27
3.1.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	28
3.1.7. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	29
3.1.8. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр.....	30
3.1.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	38
Хавсралт.....	Error! Bookmark not defined.



БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Дарханы дулааны цахилгаан станц төсөл”

1.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК

Регистрийн дугаар: 2688549

Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг,

Үйлдвэрийн дүүрэг, Өөрийн байр

Утас: 99049488, 7037-3021, 7037-3022

Факс: 7037-3021

И-мэйл: darhanpp@mongol.net

1.3. Төслийн талбайн байршил

“Дарханы дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь Дархан-Уул аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт Дархан хотын үйлдвэрлэлийн бүсэд байрлаж байна. ДДЦС-ын талбай болон Ажилчдын эмнэлэг, сувиллын талбай нь 13 дугаар багийн нутаг дэвсгэрт, Үсний сангийн талбай болон Усны эх үүсвэрийн гүний худгууд нь 18 дугаар буюу Малчин багийн нутаг дэвсгэрт байрлаж байна.



Зураг 1. Төслийн талбайн байршил, орчны төлөв байдлыг сансрын зургаар харуулав



Зураг 2. Дарханы дулааны цахилгаан станцын талбай төлөв байдлыг дроны зургаар харуулав
(250 м-ийн өндрөөс, 2023-05-13)



1.4. Төслийн товч тодорхойлолт

“Дарханы дулааны цахилгаан станц” (ДДЦС)-ыг анх Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 05-р сарын 08-ны өдрийн 222 дугаар тогтоолоор Дархан хотын үйлдвэрийн дүүрэгт барьж байгуулах шийдвэр гарч 1963 оны 11-р сарын 04-нд суурийг тавих ёслол болж 1965 оны 10-р сарын 02-нд анхны үндсэн тоноглолуудыг ашиглалтад оруулж цахилгаан дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн хэрэглэгчдэд түгээж эхэлсэн түүхтэй эрчим хүчний салбарын ууган үйлдвэрүүдийн нэг юм. Төвийн Эрчим Хүчний системийн даргын 1992 оны 12 дугаар 20-ны өдрийн 149 дүгээр тушаалаар Төрийн Өмчийн Улсын Үйлдвэрийн Газар, 2001 оны 7-р сарын 09-ний өдрийн Засгийн Газрын 164-р тогтоолоор “ДДЦС” ТӨХК болгон зохион байгуулагдсан. Тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг шаардлагын хэмжээнд хийж гүйцэтгэх чадвар бүхий мэргэжилтэй ажилтан, инженер техникийн ажилтнаар бүрэн хангагдсан. Одоогоор нийт 482 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна. Суурьшлын бүсээс зайтай, үйлдвэрийн районд байрлах, ажилчдын эрүүл ахуй, аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

Дарханы дулааны цахилгаан станцын үндсэн үйлдвэрлэл явуулж буй талбай, үнсэн сангийн талбай, усны эх үүсвэрийн гүний худгуудын талбай, сувиллын газар гэсэн үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэг бүхий газарт үйл ажиллагаа явуулдаг. Гүний худгийн талбай нь ЗД-ын 2014 оны 12 сарын 16-ны өдрийн 513 тоот, үнсэн сангийн талбай нь 2011 оны 10 сарын 31-ний өдрийн 489 тоот, үйлдвэрийн хашаа нь 2013 оны 09 сарын 23-ний өдрийн 348 тоот шийдвэрийг үндэслэн тус тус газар эзэмших гэрчилгээ үргэлжлүүлэн эзэмшүүлэхээр олгосон байна.

Дарханы дулааны цахилгааны эрчим хүчийг хослон үйлдвэрлэдэг төрийн өмчит аж ахуй нэгж бөгөөд Дархан-Сэлэнгийн бүс нутагт цахилгаан эрчим хүчээр, Монголын хоёрдогч том хот болох Дарханыг дулааны эрчим хүчээр хангадаг цор ганц цогцолбор юм. Станцын технологийн үе шатуудыг товчлон тайлбарлавал, нүүрсийг төмөр замаар тээвэрлэн ирж ил ба далд агуулахад нөөцлөн хадгалж, түүнийг бутлан түлш дамжуулах хэсгийн тоног төхөөрөмжүүдийн тусламжтайгаар шууд түлш тэжээгчээр 1, 2-р зуухны галын хотолд, цаашид үрлэн тээрмээр нунтаглан бэлтгэж сеператор ба тоосны бункерээр дайруулан 4-8-р зуухнуудын галын хотолд, харин 9-р зуухны хувьд 2 алхан тээрмээр нунтаглан шууд галын хотолд тус тус үлээлгэн оруулна. Зуухны галын хотолд тоосон нүүрсний шаталт явагдахад ялгарсан дулаан галын хотлын ханаар эгнэн байрласан экран хоолойгоор өгсөх усанд өгөгдөн түүнийг буцалган ууршуулж барабанд оруулан түүнээс цааш уурын халаагуураар дамжуулан халааж өндөр даралт, температуртай (3.5 МПа даралт, 435°C температуртай) уур боловсруулна. Зууханд боловсруулсан өндөр даралт, температуртай уураар турбиныг ажиллуулан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба турбины авлагуудаас дулааны эрчим хүчийг хэрэглэгчдэд түгээдэг.

Тус станц нь ОХУ-д үйлдвэрлэсэн БКЗ-75-39ФБ маркийн цагт 75 тонн уур боловсруулах хүчин чадалтай 9 зуух, АПТ-12-35-10 маркийн тус бүр нь цагт 12 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадалтай 4 турбин, АПТ-35/39-3.4-1.0 маркийн цагт 35 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадалтай 1 турбин генератортайгаар жилд 446.9 сая.квт.цаг цахилгаан эрчим хүч, 906 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан хүчин



чадалтайгаар ажиллаж байна. Үндсэн ба туслах тоноглолууд нь сүүлийн үеийн ухаалаг хянах хэмжүүр, автоматикийн хэрэгслүүдээр тоноглогдсон. Тус станц нь үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээ төвийн эрчим хүчний системд нийлүүлдэг ба Дархан-Сэлэнгийн бүс нутагт 6, 35, 110 кВ-ын өндөр хүчдэлийн шугамуудаар хэрэглэгчдэд түгээдэг. (110 кВ-ын шугамаар Дарханы 220 кВ-ын дэд станц, Сүхбаатар, Дархан, Ерөө, Шарын голын уурхайтай, 35 кВ-ын шугамаар Энх тал, Хонгор сумтай, 6 кВ-ын шугамаар Дарханы үйлдвэр аж ахуйн газруудтай холбогддог). Мөн Дархан хотыг бүхэлд нь хэрэгцээний халуун ус, дулаанаар бүрэн хангаж байгаагийн зэрэгцээ томоохон үйлдвэрүүдийг технологийн хэрэгцээний уураар хангаж ажилладаг. Уг цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэхэд жилд дунджаар 430-470 мян.тн нүүрсийг Шарын гол, Багануурын уурхайгаас худалдан авч технологийн хэрэгцээндээ ашигладаг ба 2020-2022 оны нүүрс зарцуулалтын тайлангаас үзэхэд жилд дунджаар 468.4 мян.тн нүүрс хэрэглэсэн байна.

- БКЗ-75-39ФБ маркийн-9 ш уурын зуух
 - Нам температурын буцлах давхаргад шатаах технологид шилжүүлсэн-2 ш зуух (Зуух №1, 2)
 - Алхан тээрэмтэй шууд үлээлгийн тоосон системд шилжүүлсэн-1 ш зуух (Зуух №9)
 - Завсрын бункер бүхий тоос бэлтгэлийн системтэй-6 ш зуух (Зуух №3-8)
- Турбогенератор-5 ш
- Мазутын агуулахын багтаамж
 - 1 ба 2-р агуулах тус бүр 500 м³
 - 3-р агуулах 700 м³
- Нөөцийн резервуарууд:
 - С-1 маркийн 40-50 тн багтаамж бүхий дизель түлшний бак-1 ш
 - 34.68 м³ багтаамжтай тосны сав 4 ш
- Эргэлтийн ус хөргөх цамхаг (градирня)-2 ш
- Утааны яндан-120 м өндөр
- Хими цэвэрлэгээний байгууламж-1 ком
 - Зөөлөрсөн усны сан 2 ш тус бүр 200 м³ багтаамжтай
 - Давсны аж ахуй-1 ком
 - Фосфатын аж ахуй-1 ком
- Нүүрсний агуулах
 - Далд сарай - 1200 тн
 - Ил сарай - 40000 тн
- Нүүрс буулгах зориулалтын өндөрлөсөн төмөр зам-2 салаа
- Нүүрсний эстакад-255 м
- Нүүрс ачиж буулгах байгууламж
- Үнсний сан-705000 м³
- Тунгаасан усны сан-80000 м³
- Бүх төрлийн инженерийн шугам сүлжээ
- Гүний ЭЦВ10-65-150 насос - 8 ком
- Гүний худаг-10 ш



БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төслийн байгаль орчны тодорхойлолт

2.1.1. Төслийн талбайн физик газарзүйн нөхцөл


“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК байрлах Дархан-Уул аймаг нь Монгол орны физик-газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их муж(II)-ийн зүүн хойд шувтаргын хэсэгт, Хангайн муж (II.1)-ийн Сэлэнгэ-Орхоны савын дундаж өндөр уулсын тойрогт байрлаж байна.

Энэ районд 1700-2000 орчим метрийн өндөртэй, Сэлэнгэ мөрөн болоод Орхон голын усан хагалбар болох Булганхан, Бүрэн зэрэг уулс оршдог. Судалгааны районы хамгийн өндөр уул Хантай бөгөөд далайн түвшнээс дээш 2123 м өргөгдсөн байдаг. Энэ хавийн уул зүйн тогтолцоо хүчтэй хотойлтонд орсон байхаас гадна гадаргуу нь ерөнхийдөө тэгшрэлд орж, эх газрын эрс тэс хуурай уур амьсгалын нөлөөллөөр физик өгөршилд автагдсан байна. Уулсын үндэс суурийг бүрдүүлэгч чулуулгийн давхарга нь эртний төрмөлийн үед үүссэн бөгөөд тектоник эвдрэлд хүчтэй орсноос атраатжилтад орж гадаргуугийн хотгор гүдгэрийг үүсгэсэн байна. Судлагдаж байгаа районы хамгийн өндөрт орших цэг нь 820.7 метрт, хамгийн нам дор цэг нь Хараа голын татмын хэсэгт 676.1 метрийн үнэмлэхүй өндөртэй байна. Голын хөндийгөөс толгодын орой хүртэлх харьцангуй өндөр нь дунджаар 100 гаруй метрт хэлбэлзэж байгаа нь нам өндөртэй толгодын рельеф зонхилж байгааг тодорхойлно. Хотын байрлаж байгаа нутаг дэвсгэрийн гадарга нь харьцангуй бага өндөрт долгиолсон байдалтай юм.

Дарханы дулааны цахилгаан станц нь үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай дулааны цахилгаан станц байрлаж буй газар нь Дархан сумын 13-р багт, ус түгээх, шахах, өргөх байгууламж, үйлдвэрийн болон аж ахуйн зориулалтын усан сангийн зориулалттай эзэмшил газрууд нь Дархан-Уул аймгийн Дархан сумын Малчин багийн нутагт тус тус байрладаг. Дарханы дулааны цахилгаан станц Дархан хотын зүүн урд хэсэгт үйлдвэрийн бүсэд “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-иас хойш 1.6 км зайд, “Дархан минж” ХХК-иас баруун тийш 1.0 км зайд, “Дархан нэхий” ХК, Дарханы арьс шир боловсруулах үйлдвэр буюу “Дархан арьс ширний цогцолбор” ХХК-иудын хойд талд байрлаж байна.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэр нь газрын гадаргын тогтоц, хөрсний бүтэц, уул зүйн байрлал зэргээрээ нэлээд өвөрмөц тогтоцтой. Монгол орны хойд хэсэгт Сэлэнгэ аймгийн төв хэсэгт, Хэнтий нурууны салбар уулсын хоорондох намхан гүвээ, толгод, Хараа голын хөндийд далайн түвшнээс дээш 705 м өндөрт 105°56’-ын уртрагт, 49°29’ өргөргийн дагуу оршдог. Тус аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ 330 мянган га бөгөөд гуу жалгаар хэрчигдсэн, тэгш биш долгиолог гадаргуутай.

Дарханы дулааны цахилгаан станц нь Дархан-Уул аймгийн төв Дархан хотын зүүн урд хэсэгт далайн түвшнээс дээш 691-693 м-ийн өндөрт 0-2 хэмийн налуу гадаргад Хараа голын хөндий хэсэгт байрлана.



Зураг 3. Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн өндөржилтийн зураг



Зураг 4. Станцын үндсэн байгууламжууд



2.1.2. Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөл

Дархан-Уул аймаг нь уур амьсгалын мужлалын хувьд ширүүвтэр өвөлтэй, дулаан зунтай, чийгээр дутмаг мужид багтана. Байгалийн эрс тэс уур амьсгалтай, жилийн 4 улирлын ялгаа ихтэй, агаарын температурын хэлбэлзэл их, хур тунадасны хэмжээ, чийг багатай цаг агаарын нөхцөлтэй.


Дархан-Уул аймгийн жилийн агаарын үнэмлэхүй бага температур $-32.0....-46.0$ градус хүрч хүйтэрдэг. Ажиглалтын 38 жилийн судалгаанаас үзэхэд 1984, 1985, 1987, 1990, 1997, 1998, 2000, 2001, 2002, 2005, 2006, 2010, 2012 онуудад $-40.0...-46.0$ градус хүрч хүйтэрч байсан. 2001 оны 01 дүгээр сард Дархан суманд -43.7 градус, Хонгор суманд -48.5 градус, Орхон суманд -46.7 градус, Шарын гол суманд -44.0 градус хүрч үнэмлэхүй их хүйтэн ажиглагдсан байна. 38 жилийн өөрчлөлтийн шугаман трендийн тэгшитгэлийн өнцгийн итгэлцүүр (а-коэффициент)-ийн утга өөрчлөлтгүй байна.

Олон жилийн судалгаагаар агаарт 30 градусаас давж хүйтэрсэн өдрүүдийн хамгийн олон тохиолдол нь Дархан суманд 1984, 1985 онуудад 61-65 өдөр, Хонгор суманд 2001, 2005, 2012 онуудад 75-80 өдөр, Шарын гол суманд 2010, 2012 онуудад 52-59 өдөр, Орхон суманд 1985, 2005 онуудад 66-78 өдөр тус тус ажиглагдаж, цаг агаарын нөхцөл хүндэрч байсан бол сүүлийн 2018 оноос хойш өвлийн улирлын үнэмлэхүй их хүйтэн утгад хүрэхгүй дулаан жилүүд болсон.

Хөрсний гадаргын үнэмлэхүй бага температур $-36.3...-49.2$ градус хүрдэг. 1984-1986, 1998-1999, 2000-2002, 2005-2006, 2008, 2010, 2012 онуудад $-44.0...-49.5$ градус хүрч хүйтэрсэн байна. Ажиглалтын 38 жилийн хугацаанд хөрсөн дээр 1999 оны 1 дүгээр сард Дархан суманд -49.2 градус, 2001 оны 1 дүгээр сард Шарын гол суманд -47.3 градус, Хонгор суманд -49.0 градус, 1999 оны 1 дүгээр сард Орхон суманд -49.6 градус хүрч үнэмлэхүй хүйтэн ажиглагдсан.

Дархан-Уул аймгийн нутгаар олон жилийн дунджаар жилд 295-307 мм хур тунадас унадаг. Хур тунадасны 38 жилийн дунджийн явцаас харахад 2021 онд хамгийн их 451.2 мм, 1996 онд хамгийн бага 187.5 мм тунадас унасан байна. Тунадасны жилийн дундаж явцаас харахад 1984-2007 он хүртэл 187.5-411.5 мм-ийн хооронд хэлбэлзэж байсан ба 2008-2021 онд хүртэл 276.7-525.7 мм хур тунадасны хэлбэлзэж орсон байна.

Олон жилийн судалгаагаар хойд, баруун хойд, өмнийн салхи ноёлдог бол 2022 онд хойд, зүүн хойд ба өмнө зүгээс давамгайл салхилжээ. Олон жилийн дунджаар өмнө ба хойдын салхи 13-31 удаа байдаг бол 2022 онд 15-24 давтагдлаар илүү ажиглагдсан. Олон жилийн дунджаар Салхины хурдны дундаж 2.4 м/сек, 2022 онд 2.0 м/сек болж 0.4 м/сек-ээр бага салхитай байлаа. Салхины үнэмлэхүй их хурд Дархан, Орхон, Хонгор суманд 22 м/сек, Шарын гол суманд 27 м/сек хүрч салхилсан. 10 м/с-ээс дээш хурдтай салхитай өдөр Дархан суманд 112, Хонгор суманд 83, Орхон суманд 99, Шарын гол суманд 154 удаа тохиолдсон байна.



Зураг 5. Салхины зүгийн тохиолдол ба дундаж хурдны тооны харьцуулалт

2.1.3. Агаарын чанарын төлөв байдал

“Дарханы дулааны цахилгаан станц төсөл”-ийн үйл ажиллагаанаас ялгарч буй агаарын бохирдол нь хүрээлэн буй орчинд үзүүлж буй гол сөрөг нөлөөлөл болж байна. Мөн хүчтэй дуу шуугианы бохирдол үзүүлнэ. Эдгээр бохирдлын эх үүсвэрүүд станцын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тэр дундаа усны ашиглалт-эргэлтийн систем, яндан, нүүрс хадгалах талбай, үнс зайлуулах систем, үнсэн сангийн талбай зэрэг болно.

Станцын хаягдал утаа нь нэлээд өргөн нутаг дэвсгэрийг хамарч тархдаг тул талбайн хэмжээнд болон бамбар утааны чиглэлийн дагуу нийт 6 цэгийг сонгон агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгэсэн. Хэмжилтийн цэгүүдийн ойролцоох объектын нэршил, солбицлыг дараах хүснэгтэд, байршлыг үзүүлэв (Хүснэгт 17, Зураг 31).



Зураг 6. Төслийн талбайн байршил, хамрах хүрээ



Хүснэгт 1. Төслийн талбай орчмын агаарын чанарын үзүүлэлт

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий мкг/м ³	Азотын давхар исэл мкг/м ³	Нийт тоос, мкг/м ³
1	Станцын зуухны барилгын орчим (49° 26' 13.3" N 105° 57' 32.5" E)	2023.5.13	16	33	285
2	Үйлдвэрийн хашааны гадна талд (49° 26' 16.2" N 105° 57' 36.8" E)	2023.5.13	5	16	142
3	Станцын яндангийн орчим (49° 26' 09.8" N 105° 57' 26.7" E)	2023.5.13	14	28	180
4	Станцын яндангаас 500 м зайд (49° 25' 55.3" N 105° 57' 15.9" E)	2023.5.13	7	21	110
5	Станцын яндангаас 1000 м зайд (49° 25' 44.0" N 105° 56' 56.9" E)	2023.5.13	11	26	125
6	Станцын яндангаас 1500 м зайд (49° 25' 29.9" N 105° 56' 44.2" E)	2023.5.13	16	31	230
MNS 4585:2016 Агаарын чанарын стандарт (20 минутын дундаж зөвшөөрөгдөх дээд хэмжээ)			450	200	500

Тайлбар:


- Тухайн сорьц авах, хэмжилт хийх хугацааны цаг агаарын нөхцөл: Агаарын чийгшил 47%, агаарын температур 12.4 градус дулаан, салхи хойдын зүүн хойноос 3-8 м/с хурдтай байсан.
- Агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламж MNS4585:2016 стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давсан бохирдолгүй.

Шинжилгээний дүнгээс харахад агаар бохирдуулах бодисуудын агууламж Монгол улсын агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016-д заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон ажлын байрны холбогдох стандартад зааснаас нормоос хэтрээгүй байна. Мөн орчны шуугианы төвшин холбогдох стандартад заасан нормын хэмжээнд байсан ба Мазутын агуулах орчим хэмжилт хийх үед талбайд хэд хэдэн механизм ажиллаж байсан нь шуугиан түвшин харьцангуй өндөр хэмжигдэхэд нөлөөлжээ.

2.1.4. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн судалгаа

Дарханы дулааны цахилгаан станцын талбай, үнсэн сангийн талбай, цэвэр усны худгийн талбайн хэмжээнд нийт цэгт 12 (Дулааны станцын талбайд-9, Үнсэн сангийн талбайд-2, Цэвэр усны худаг 1 цэг) цэгт хээрийн хэмжилт судалгаа, дээжлэлтийг хийж лабораторийн шинжилгээнд зориулан 12 ширхэг хөрсний дээж тус тус авсан.

Бидний судалгаагаар хээрийн хэмжилт хийсэн цэгүүдэд тухайлбал Дулааны цахилгаан станцын талбайд Элсэнцэр Хүрэн хөрс, үнсэн сан болон цэвэр усны худын талбайн хэмжээнд аллювийн глейрхэг төрлийн хөрснүүд тархсан байна. Аллювийн бүлгийн Бараан хэв шинжийн хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин өндөртэй буюу ялзмагийн агууламж нь 5%-иас их байдаг.



Зураг 7. Дулааны цахилгаан станцын талбайн хөрсний зураг

Хөрсний цэгүүдийн гадаргын төлөв ба үе давхаргын шинж чанар

Цэгийн дугаар 1 (Дарханы ДЦС): Ногоон байгууламж, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол E105.9595469, N49.4379, Баруун хойноос Зүүн урагш чиглэсэн их хэвгий 30 градус налуутай, зориудаар ухаж бэлдсэн гадарга, ургамлын бүрхэц 70-80%, хөрсний гадарга дээрх чулууны бүрхэц 5-10%, давсжилт ба намагжилт байхгүй, хөрсний доройтол дунд зэрэг, гадаргын бохирдол байхгүй, Элсэн Хүрэн хөрстэй.

Цэгийн дугаар 2 (Нүүрс буулгах талбайн орчимд): Дулаан цахилгаан станцын нүүрс буулгах талбайн орчимд, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N49.43507222, E 105.9588028, Тэгшивтэр, ерөнхий ландшафтын хувьд хүний үйл ажиллагаагаар өөрчлөгдсөн, гадаргад чулуугүй, ургамлын бүрхэц 50%, давсжилт ба намагжилт байхгүй. хөрс, доройтол их, гадарга нүүрсээр бохирдсон, Элсэнцэр Хүрэн хөрстэй.



Цэгийн дугаар 3 (Хашаалсан талбайн зүүн үрд хэсэгт): Дулааны цахилгаан станцын хашаалсан талбайд, эвдрэл доройтолд ороогүй гадарга. Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43391083, E 105.9562775, Тэгшивтэр, ерөнхий ландшафт хүний үйл ажиллагаагаар өөрчлөгдсөн, хөрсний гадарга дээрх тоос, тортог ихтэй, давсжилт бага зэрэг ба намагжилт байхгүй, хөрсний доройтол их, гадаргын бохирдол байхгүй, Элсэнцэр Хүрэн хөрстэй (Станцын яндангаас гарч буй нарийн ширхэгтэй материал болон бусад үйл ажиллагаагаар гадаргын өнгөн хэсэгт нарийн ширхэгтэй материал хуримтлагдсан).

Цэгийн дугаар 4 (D-4): Дулааны цахилгаан станцын яндангийн орчмын талбай, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43613889, E 105.9572806, Тэгшивтэр, Ерөнхий ландшафт нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсөн, гадарга маш их дэгдэмхий тоосорхог, хөрсний давсжилт их ба намагжилт байхгүй, хөрсний доройтол их, Элсэнцэр Хүрэн хөрс тархсан гэвч яндангаас ялгарч буй тоос, тортгийн нөлөөгөөр гадаргын өнгөн хэсэгт нарийн ширхэгтэй хэсэг хуримтлагдсан.

Цэгийн дугаар 5 (D-5): Нефтийн бүтээгдэхүүн хадгалах агуулахын орчим, станцын хөрсний мониторинг цэг, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43637222, E 105.9585694, Тэгшивтэр, Ерөнхий ландшафт нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсөн, гадаргад зориудаар өөр төрлийн хөрс, чулуулаг гадаргад байршуулсан, хөрсний гадарга дээрх чулуу 20%, давсжилт их ба намагжилт байхгүй, хөрсний доройтол их, Элсэнцэр Хүрэн хөрстэй (Тархсан бүсэд).

Цэгийн дугаар 6 (D-6): Нефтийн бүтээгдэхүүн хадгалах агуулахын орчим, станцын хөрсний мониторинг цэг, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43711361, E 105.9543, Тэгшивтэр, Ерөнхий ландшафт нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсөн, гадаргад зориудаар өөр төрлийн хөрс, чулуулаг гадаргад байршуулсан, хөрсний гадарга дээрх чулуу 10-20%, давсжилт ба намагжилт байхгүй, хөрсний доройтол их, Аллювийн хайрган хөрстэй.

Цэгийн дугаар 7 (D-7): Уурын байгууламжийн орчим, станцын хөрсний мониторинг цэг, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43711361, E 105.9543, 8-15 хэм хэвгий гадарга, Ерөнхий ландшафт нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсөн, эвдрэлд орсон элсэрхэг хөрстэй, хөрсний гадарга дээрх чулуу 5-10%, давсжилт ба намагжилт байхгүй, хөрсний доройтол их, Элсэнцэр Хүрэн хөрстэй (Бүсэд тархсан) нарийн тоосорхог материал хөрсний гадаргад хуримтлагдсан.

Цэгийн дугаар 8 (D-8): Шатахуун түгээгүүр орчим, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43566944, E 105.9618389, 3-5 хэм хэвгий гадарга, Ерөнхий ландшафт нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсөн, эвдрэлд орсон элсэрхэг хөрстэй, хөрсний гадарга дээрх чулуу 5-10%, давсжилт ба намагжилт байхгүй, хөрсний доройтол их ба шатахуун хүлээн авах байгууламжид асгарсан ул мөргүй, түгээх байгууламж орчимд шатахуун асгаралт ихтэй, Элсэнцэр Хүрэн хөрстэй (Бүсэд тархсан) нарийн тоосорхог материал хөрсний гадаргад хуримтлагдсан.


Цэгийн дугаар 9 (D-9): Үнсэн сангийн нөхөн сэргээсэн талбайд, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43765528, E 105.9305944, 1-3 хэм хэвгий гадарга, Ерөнхий ландшафт нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсөн, нөхөн сэргээсэн талбайн Хархүрэн хөрс ашигласан, нөхөн техникийн нөхөн сэргээлтийн хэвгийжүүлэлт сайн, биологийн нөхөн сэргээлтийн үр дүн тухайлбал ургамлын бүрхэц бага, сийрэг байна. Ашиглалтад байгаа үнсэн сангийн нөлөөгөөр гадаргад нарийн тоосорхог материал хөрсний гадаргад хуримтлагдсан.

Цэгийн дугаар 10 (D-10): Үнсэн сангийн нөхөн сэргээсэн болон ашиглаж буй талбайн орчимд, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.43911389, E 105.9253389, 5-8 хэм хэвгий гадарга, Ерөнхий ландшафт нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр өөрчлөгдсөн. Ашиглалтад байгаа үнсэн сангийн нөлөөгөөр гадаргад нарийн тоосорхог материал хөрсний гадаргад хуримтлагдсан. Гадаргад давсжилттай, үнсэн сангийн тоосны нөлөөгөөр гадарга нь давсжиж байна.

Цэгийн дугаар 11 (D-11): Гүний худаг орчим, Дархан-Уул аймаг. Огноо 2023.05.13, солбицол N 49.44265278, E 105.9224806, 1-3 хэм хэвгий гадарга, Голын татам, нугархаг гадарга, хөрс эвдрэл доройтолд бага зэрэг орсон, үндсэн ландшафтад өөрчлөлт байхгүй. Аллювийн хөрстэй, ул хөрсний усны нөлөөгөөр хөрс бага зэрэг давсжилттай.


Хөрсөн бүрхэвчид үзүүлсэн сөрөг нөлөөлөл

ДДЦС-ын эзэмшил газрын талбайн хэмжээ 25.6 га байна. Үүнээс, 9.6 га газар нь барилга байгууламж, зам талбай зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртсөн байх бөгөөд хөрсөн бүрхэвч бүхий сул чөлөөтэй талбай нь 16 га байна. Үүнээс, 2.5 га талбайг зүлэгжүүлж, мод тарьсан ногоон байгууламж бүхий эзэлнэ. ДДЦС-ын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртөөгүй хөрсөн бүрхэвч бүхий сул чөлөөтэй 16 га талбайгаас 2.6 га талбайн хөрсөн бүрхэвч хүчтэй сөрөг нөлөөлөлд буюу эвдрэлд өртсөн байна.



Зураг 8. Хөрсөн бүрхэвч хүчтэй сөрөг нөлөөлөлд буюу эвдрэлд өртсөн талбайнууд

Дээрх зурагт үзүүлсэн эвдрэлд өртсөн хөрсөн бүрхэвч бүхий талбайнуудын зарим хэсэг нь үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой талхагдлын сөрөг нөлөөллөөр хөрсөн бүрхэвчгүй болсон байхад зарим хэсэг нь машин техникийн хөдөлгөөнөөс үүссэн шороон замын нөлөөллөөр хөрсөн бүрхэвчгүй болсон байна. Иймд эдгээр талбайнуудын зарим хэсэг буюу 1.8 га талбайг нь хатуу хучилттай болгох, зарим хэсэг буюу 0.8 га талбайг нь нөхөн сэргээж ургамалжуулах шаардлагатай гэж үзэв.



Зураг 9. Эвдрэлд өртсөн талбайнуудын ангилал

2.1.5. Төслийн талбайн ургамлын судалгаа

“Дарханы дулааны цахилгаан станц” орчмын нутаг нь уулын хээрийн үетэн – алаг өвст бүлгэмдэлд хамрагдах бол үнсэн сангийн талбай орчмын ургамлан нөмрөг нь татамын нугын Алаг өвс – Дэрс – Улалжит ургамлан бүлгэмдэлтэй байна. Дулааны цахилгаан станцын ойр орчмын ургамлан нөмрөг нь төв суурьшлын нөлөөгөөр маш хүчтэй талхагдаж халцгайрсан бол станцын хашаан доторх ургамлан нөмрөг нь ашиглагдаагүй сул талбайд алаг өвс – үетэнт ургамлан нөмрөгтэй бөгөөд ногоон байгууламжийн талбайд мод, бут, сөөг болон өвслөг ургамлууд тохиолдож байна. Төслийн талбайн ургамлан нөмрөг газар ашиглалтын байдлаас хамааруулан 11 цэгт ургамлын бичиглэл хийсэн.

Станцын талбайд алаг өвс – үетэнт бүлгэмдлийг дагаж өвслөг ургамлаас Крыловын хялгана *Stipa Krylovii*, Нангиад цагаан суль *Elymus chinensis*, Дагуур өлөнгө *Elymus dahuricus*, Нугын биелэг *Poa pratensis*, Соргүй согоовор *Bromus inermis*, Ногоон хоног будаа *Setaria viridis*, Бага хургалж *Hemerocallis minor*, Саваан булган сүүл *Chloris virgata*, Саман ерхөг *Agropyron cristatum*, Гялгар дэрс Ширэг улалж *Carex duriuscula*, Шар царгас

Medicago falcata, Нумраа хунчир *Astragalus adsurgens*, Шүдлэг хошоон *Melilotus dentatis*, Хижээл сонгино *Allium senescens*, Арзгар согсоолж *Heterorapphus hispidus*, Нугын шимтэглэй *Geranium pratense*, Амуухай бангацаг *Ixeridium gramineum*, Хөдөөгийн чөдөр сэдэргэнэ *Convolvulus arvensis*, Имт гичгэнэ *Potentilla bifurca*, Хигмэл гичгэнэ *Potentilla multifida*, Нүцгэн намуу *Papaver nudicaule*, Эмийн багваахай *Taraxacum officinalis*, Таван салаа *Plantago depressa Willd.*, Эгэл гоньд *Carum carvi*, Цагаан лууль *Chenopodium album*, Агь *Artemisia frigida Willd.*, Монгол шарилж *Artemisia mongolica*, Ямаан шарилж *Artemisia scoparia*, Царвант шарилж *Artemisia sieversiana*, Ишгэн шарилж *Artemisia dracuncululus L.*, Өмхий шарилж *Artemisia adamsii Besser*, Бөөн цэцэгт цангуу *Lepidium densiflorum*, харин дулааны цахилгаан станцын барилга байгууламжийн орчны ногоон байгууламжид олон наст өвслөг ургамлуудаас гадна Сибирь гацуур *Picea obovata ldb*, Шар хуайс *Caragana arborescens.*, Лавар навчит улиас *Populus laurifolia Ledeb. L.*, Одой хайлаас *Ulmus Pumila L.*, Бургас *Salix sp*, Чацаргана *Hippophae rhamnoides L*, Эгэл нарс *Pinus sylvestris L.* зэрэг модлог ургамлууд тарьж ургуулсан байна.



Зураг 10. Дарханы ДЦС-ын ногоон байгууламж

Үнсэн сангийн талбай: Үнсэн сангийн талбай нь голын хөндийд байрлаж байгаа учраас ерөнхийдөө дэрс оролцсон алаг өвс – Дэрс – Улалжит ургамлан бүлгэмдэл тохиолдоно. Харин үнсэн сангийн нөхөн сэргээсэн талбайд дэрс оролцсон шарилж-алаг өвст бүлгэмдэл тохиолдож байна. Үнсэн сангийн нөхөн сэргээсэн талбайн ургамлан нөмрөг маш сайн ургасан нөхөн сэргээлтийн үр дүн маш сайн байгаа нь хээрийн судалгааны үед ажиглагдаж байв.




Зураг 11. Үнсэн сангийн нөхөн сэргээсэн талбай

Үнсэн сангийн орчмын Алаг өвс - Дэрс – Улалжит ургамлан бүлгэмдлийг дагаж Шүлхий шарилж *Artemisia pectinata*, Гялгар дэрс *Achnatherum splendens*, Ширэг улалж *Carex duriuscula*, С.А.Мей., Нангуад цагаан суль *Elymus chinensis*, Дэрвээн хазаар өвс *Cleistogenes squarrosa*, Нугын биелэг *Poa pratensis* L., Монгол улаантолгой *Agrostis mongolica* Roshev., Тавансалаа *Plantago major* L., Цагаалин цахилдаг *Iris lacteal* Pall., Крыловын хялгана *Stipa Krylovii*, Саман ерхөг *Agropyron cristatum*, Олслиг халгай *Urtica cannabina* L, Адамсын шарилж *Artemisia adamsii*, Агь шарилж *Artemisia frigida*, Ээрэм шарилж *Artemisia sieversiana*, Сортой лууль *Chenopodium aristatum* L., Имт гичгэнэ *Potentilla bifurca*, Хигмэл гичгэнэ *Potentilla multifida*, Нүцгэн намуу *Papaver nudicaule*, Эмийн багваахай *Taraxacum officinalis*, Таван салаа *Plantago depressa* Willd., Эгэл гоньд *Carum carvi*, Ишгүй гичгэнэ *Potentilla acaulis*, Галуун гичгэнэ *Potentilla anserina*, Марал навчит гичгэнэ *Potentilla tanacetifolia* Willd., зэрэг ургамлууд үнсэн сангийн ойр орчимд түгээмэл тохиолдоно.



Зураг 12. Алаг өвс – Дэрс – Улалжит бүлгэмдлийн ерөнхий төлөв байдал



Зураг 13. Төслийн талбайн ургамлан бүлгэмдэл



ДДЦС-ын эзэмшил газрын талбайн хэмжээ 25.6 га байна. Үүнээс, 9.6 га газар нь барилга байгууламж, зам талбай зэрэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртсөн байх бөгөөд ургамлан нөмрөг бүхий сул чөлөөтэй талбай нь 16 га байна. Үүнээс, 2.5 га талбайг зүлэгжүүлж, мод тарьсан ногоон байгууламж бүхий талбай эзэлнэ.

ДДЦС-ын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртөөгүй ургамлан нөмрөг бүхий сул чөлөөтэй 16 га талбайгаас 2.6 га талбайн ургамлан нөмрөг хүчтэй сөрөг нөлөөлөлд өртөж устсан байна.

Станцын нүүрс буулгалтын талбай, төмөр замын эргэн тойрондох ургамлан нөмрөг тоосонд дарагдах сөрөг нөлөөлөлд өртсөн байна. Мөн маслын банкны хадгалалтаас үүдэн масло асгарсан байх бөгөөд тухайн хэсгийн ургамлан нөмрөг халцарч устах сөрөг нөлөөлөл үзүүлнэ.


Үнсэн сангийн хувьд авч үзвэл нийт талбайн хэмжээ 103.2 га бөгөөд үүнээс 34.9 га талбайд үнсэн сан болон үнсэн сангийн тунгаах нуур үүсэж ургамлан нөрмөггүй болсон байна. Харин өмнө нь үнсэн сан байсан 53.4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж ургамалжуулсан байна. Уг 53.4 га талбайд нөхөн сэргээлт хийснээр үнсэн сангийн шууд нөлөөллийг 50 орчим хувиар бууруулсан байна.

Дарханы дулааны цахилгаан станц төслийн талбай болон үнсэн сангийн орчимд уулын хээрийн алаг өвс – үетэнт, голын хөндийн алаг өвс – Дэрс – Улалжит татмын нугын бүлгэмдэл гэсэн үндсэн 2 төрлийн ургамлан бүлгэмдэл тохиолдож байна. Уг 2 бүлгэмдэл буюу уулын хээрийн алаг өвс-үетэн, татмын нугын алаг өвс-дэрс-улалжит бүлгэмдлийг дагаж 33 овогт хамаарагдах 100 гаруй төрлийн 150 орчим зүйл ургамал тохиолдож байна. Төслийн талбайн газар ашиглалт буюу нөлөөлөл ургамлын хэв шинжээс хамааруулан 11 цэгт ургамлын бичиглэл хийсэн бөгөөд тухайн 11 цэгийн ургамлын тусгаг бүрхэц, зүйлийн тохиолдцыг тооцож үзэхэд ургамлын тусгаг бүрхэц хамгийн багадаа 40 – 50% байхад хамгийн ихдээ 80 – 85 %, дунджаар 70 – 75 %-ийн бүрхэцтэй байна. Харин зүйлийн тохиолдцын хувьд авч үзвэл 1 м² талбайд хамгийн багадаа 5 зүйл тохиолдож байсан бол хамгийн ихдээ 11 зүйл, дунджаар 7-8 зүйл тохиолдож байна. Харин 10 м² талбайд хамгийн багадаа 11 зүйл, хамгийн ихдээ 21 зүйл, дунджаар 14-16 зүйл тохиолдож байна. Судалгааны талбайд хээрийн судалгааны үед хуулиар хамгаалагдсан ховор болон нэн ховор ургамлын төрөл зүйл тохиолдоогүй. Судалгааны талбайн ургамлын нормчлогдсон ялгаврын индекс буюу NDVI-ийг 2022 оны 8 сарын ландсат-8 хиймэл дагуулын мэдээг боловсруулалт хийж үзэхэд хамгийн ихдээ NDVI утга 0.61 буюу дунджаас их ургамлан нөмрөгтэй байхад хамгийн бага утга -0.1 буюу огт ургамлан нөрмөггүй байна.

2.1.6. Гадаргын ус

“Дарханы дулааны цахилгаан станц төсөл”-ийн талбай нь ус зүйн хувьд Хараа голын сав газарт багтдаг. ДДЦС-ын үйл ажиллагаанаас гадаргын ус буюу Хараа голд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй гол хүчин зүйлс нь үсний сангийн үйл ажиллагаа, үнсний сангаас дэгдэх тоосонцрын бохирдол, станцын яндангаас гарах тоосонцрын бохирдол

зэрэг болно. ДДЦС-ын станцын талбай нь Хараа голоос 3.3 км зайд, үсний сангийн талбай нь 1.2 км зайд, усны эх үүсвэр нь 0.6 км зайд тус тус байрлаж байна.



Зураг 14. Хараа гол ба төслийн талбай хоорондын зай

2.1.7. Газрын доорх ус

